



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Евро эм” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/115/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ
Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn
Аудитор: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1. Залруулсан алдаа	6
3.2. Төлбөрийн акт	6
3.. Албан шаардлага.....	6
3.4. Зөвлөмж.....	7
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	9
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	9
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл	10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-13 № 587
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ЕВРО ЭМ ӨЭМТ-ИЙН
ДАРГА Ч.ЭРХЭС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро эм ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро эм ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 525.5 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 174.3 сая төгрөгийн, шүдний үзлэгийн орлогоор 0.9 сая нийт 700.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 94 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 96.7 хувь,

1426050495

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргийн 2026\2026\word\ywan bichig\Dugnet_2026.docx

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 89.5 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	39,217.38	4,490,388.52
1.1.2 Дансны авлага	117,491,120.10	8,051,751.60
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	313,911.18	301,927.71
1.1.4 Бусад авлага	-	-
1.1.6 Бараа материал	80,585,054.75	78,359,417.84
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	198,429,303.41	91,203,485.67
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	191,763,020.37	143,536,100.56
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	191,763,020.37	143,536,100.56
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	390,192,323.78	234,739,586.23
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1 Дансны өглөг	21,539,681.00	599.98
2.1.1.2 Цалингийн өглөг	216,167.81	-
2.1.1.3 Татварын өр	-	395,749.03
2.1.1.4 НДШ - ийн өглөг	8,821,750.00	10,703,699.54
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	30,577,598.81	11,100,048.55
2.2 Өр төлбөрийн нийт дүн	30,577,598.81	11,100,048.55
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	37,068,346.00	37,068,346.00
2.3.1.1 - төрийн	37,025,546.00	37,025,546.00
2.3.1.2 - хувийн	42,800.00	42,800.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	433,800.00	433,800.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	322,112,578.97	186,137,391.68
2.3.9 Эздийн өмчийн дүн	359,614,724.97	223,639,537.68
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	390,192,323.78	234,739,586.23

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг (алдагдал)	-	-
4. Санхүүжилтийн орлого	1,084,743,797.51	700,724,515.90
5. Хүүний орлого	-	2,320.78
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,115,273.46
8. Бусад орлого	65,515,125.40	9,306,922.55
9. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10. Ерөнхий ба удирдлагын зардал	1,164,590,967.85	842,329,099.12
11. Санхүүгийн зардал	-	-
12. Бусад зардал	-	-
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(14,332,044.94)	(125,180,066.43)
19. Орлогын татварын зардал	-	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(14,332,044.94)	(125,180,066.43)
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(14,332,044.94)	(125,180,066.43)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(9,686,088.82)	(9,686,088.82)
2. Залруулсан үлдэгдэл	37,068,346.00	433,800.00	336,444,623.91	373,946,769.91
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(14,332,044.94)	(14,332,044.94)
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	37,068,346.00	433,800.00	322,112,578.97	359,614,724.97
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(10,795,120.86)	(10,795,120.86)
10. Залруулсан үлдэгдэл	37,068,346.00	433,800.00	311,317,458.11	348,819,604.11
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(125,180,066.43)	(125,180,066.43)
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	37,068,346.00	433,800.00	186,137,391.68	223,639,537.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1 Мөнгөн орлогын дүн	1,065,537,283.41	819,473,127.73
1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	459,755,850.00	-
1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	596,810,933.41	806,663,884.40
1.1.6 Бусад мөнгөн орлого	8,970,500.00	12,809,243.33
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,042,520,172.13	813,222,056.59
1.2.1 Ажиллагчдад төлсөн	619,143,331.86	493,300,005.63
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	143,427,215.09	132,109,097.73
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	184,999,412.00	53,000,647.00
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	42,191,967.18	3,420,738.14
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл төлсөн	2,420,550.00	5,112,828.00
1.2.6 Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	-	507,000.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	50,337,696.00	125,771,740.09
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,017,111.28	6,251,071.14
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
2.2 Мөнгөн зарлагын дүн	23,549,800.00	1,799,900.00
2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,549,800.00	1,799,900.00
2.2.2 Бусад зардал	10,000,000.00	-
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,549,800.00)	(1,799,900.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(532,688.72)	4,451,171.14
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	571,906.10	39,217.38
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,217.38	4,490,388.52

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1. Залруулсан алдаа

Аудитаар нийт 4,700.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулсан.

- Харилцах дансанд өмнөх оны актын төлбөр 4,400.0 мянга, бэлтгэн нийлүүлэгчид илүү шилжүүлсэн 300.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 54,533.4 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмж өгч, нийцлийн аудиттай холбоотой 4,636.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 51,613.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн санхүүгийн тайлагналтай холбоотой 54,533.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс 11,771.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.2. Төлбөрийн акт

- Нөхөрлөлийн 2025 оны 01 тогтоолыг үндэслэн даргын Б/03 дугаар Б/03 тушаалаар даргын Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн сургалтын төлбөрт 4,636.0 мянган төгрөгийг төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" заалтад заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрт зарцуулсан 4,636.0 мянган төгрөгийг байгууллагын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.. Албан шаардлага

- Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 51,613.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1. Тус байгууллагын нярав эм, бараа материалын зарцуулалтын тайланг сар бүр гарган, нягтлан бодогч хянаагүй эхний 6 сарын байдлаар 35,268.3 мянган төгрөгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг сар бүр гарган үлдэгдлийг тоолж баталгаажуулж, санхүүгийн тайланг зөв илэрхийлж, цаашид хууль тогтоомжид заасны дагуу бараа материалын тайланг гарган баталгаажуулж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2. Нийслэлийн БЗД-ийн Нийгмийн даатгалын хэлтсээс тус байгууллагын 2020-2024 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 2024 оны ажиллагсадтай холбоотой шимтгэлийн дутуу төлөлтөд 10,703.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан ба дээрх өглөгөөс алдангийг хасаж 7,135.8 мянган төгрөгийг буруутай албан тушаалтан ажилтнаар төлүүлэхээр тогтоосныг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийн 7,135.8 мянган төгрөгийн авлагыг 2026 оны 1 дүгээр улирлын тайланд тусган буруутай албан тушаалтнаар төлүүлэн зөрчлийг арилгаж, цаашид хууль тогтоомжийг бүрэн мөрдөн ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-3. Эм боох материалын дансанд 7,485.6 мянган төгрөгийн бусад тусгай зориулалтын багаж, эмнэлгийн хэрэгслийг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*Толилуулга*”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм, эмнэлгийн хэрэгслийн эмчилгээ, шинжилгээнд хэрэглэх эмийг тайландаа тусган бусад эмнэлгийн тусгай зориулалтын багаж хэрэгслийг ангилан зөв бүртгэж зөрчлийг арилган, цаашид хөрөнгийг орлого авахдаа зөв ангилж бүртгэж байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-4. Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 4,643.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” заалтад заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгчдээр цахим төлбөрийн и-баримтыг бүрэн шивүүлж гүйлгээг хийж баталгаажуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Харилцах дансаар хийгдсэн 4,700.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд бүртгээгүй.	1	4,700.0	1	4,700.0			1	4,700.0				
Дүн	1	4,700.0	1	4,700.0	-	-	1	4,700.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын нярав эм, бараа материалын зарцуулалтын тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулаагүй зарлагыг эхний 6 сарын байдлаар 35268.3 мянган төгрөгийн тайланг нэгтгэн тайлагнасан.	1	35,268.3					1	35,268.3
НДХ-ээс хийсэн шалгалтаар 7,135.8 мянган төгрөгийг буруутай албан тушаалтан ажилтнаар төлүүлэхээр тогтоосныг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	7,135.8	-	-	-	-	1	7,135.8
Цахим төлбөрийн и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 4,643.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.	1	4,643.7					1	4,643.7
Эм боох материалын дансанд 7,485.6 мянган төгрөгийн бусад тусгай зориулалтын багаж, эмнэлгийн хэрэгслийг бүртгэсэн	1	7,485.6					1	7,485.6
Дүн	4	54,533.4			-	-	4	54,533.4

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 51,613.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	51,613.7			1	51,613.7		
Байгууллагын даргын Удирдлагын академийн сургалтын төлбөрт 4,636.0 мянган төгрөгийг төлсөн.	1	4,636.0	1	4,636.0				
Дүн	1	56,249.7	1	4,636.0	1	51,613.7	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНӨҮГ		1			1			
	НИЙТ		1			1			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 15

№ 120/15197/0235

Улаанбаатар хот

НТАГ-2026/115/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро Эм Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нөхөрлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн даргын Б/03 тушаалаар Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн сургалтын төлбөрт 4,636,000.0 (дөрвөн сая зургаан зуун гучин зургаан мянган) төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Сургалтын төлбөрт зарцуулсан 4,636,000.0 (дөрвөн сая зургаан зуун гучин зургаан мянган) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро Эм ӨЭМТ-ийн дарга (Ч.Эрхэс)-аар төлүүлж Евро эм Өрхийн эрүүл мэндийн төвийн Хас банкин дахь 5000043026 дугаартай байгууллагын харилцах дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро Эм Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Ч.Эрхэс), нягтлан бодогч (Б.Сарантуяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ

А.ЦЭЭНЯМ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110194



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 289/Б.197.0235

Улаанбаатар хот

НТАГ-2026/115/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Евро Эм Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 51,613,700.0 (тавин нэгэн сая зургаан зуун арван гурван мянга долоон зуун) төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Евро Эм Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Эрхэс, нягтлан бодогч Б.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090438